



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

Медаль хийлгэхэд шаардагдах хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейболын тэмцээний медаль хийж гүйцэтгэх гэрээг “Гоёл трэйд” ХХК-тай байгуулж, стандартын түвшинд ажлыг гүйцэтгүүлэхийг Спортын хөгжлийн хэлтсийн дарга /С.Саранцэцэгт/-д даалгасугай.


2. Тэмцээний медаль хийж гүйцэтгэхэд шаардагдах 9.240.000 /есөн сая хоёр зуун дөчин мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спорты хорооны
даргын 2018 оны *11 дугаар* сарын *27*-ны өдрийн
А/61 дугаар тушаалын хавсралт



Медаль хийлгэхэд шаардагдах төсөв

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн /төг/
1.	Спорт медаль /Сагсан бөмбөг/ Алт 82ш Мөнгө 82ш Хүрэл 82ш	246 ш	20.000 төг	4.920.000
2.	Спорт медаль /Волейбол/ Алт 57ш Мөнгө 57ш Хүрэл 57ш	171 ш		3.420.000
3.	Ган хэв, модель, загварын үнэ	2ш	450.000	900.000
ДҮН:				9.240.000